



ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,  
“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 10 дугаар  
сарын 29 -ны өдөр

Дугаар А/106, А/123

Чойбалсан  
хот

Журам батлах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.6, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-ийн 9.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах /код-132/ журам”-ын 132.5.2-ын “Г”, “ДБЭХС” ТӨХК-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйл шалган нэвтрүүлэх, гаргах журам”-ыг нэгдүгээр, объектод нэвтрэх байнгын үнэмлэхийн загварыг хоёрдугаар, бараа материал нэвтрүүлэх зөвшөөрлийн хуудсыг гуравдугаар, объектоос гаргах бараа, материалын зөвшөөрлийн хуудсыг дөрөвдүгээр, объектод гадны иргэнийг хүлээн авч уулзах, нэвтрүүлэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг тавдугаар, объектод иргэнийг хүлээн авч уулзах, нэвтрүүлэх эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтан объектод иргэн, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хуудасны загварыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг мөрдүүлж ажиллахыг Дорнод аймгийн Дотоодын цэргийн 826 дугаар тусгай салбарын харуул хамгаалалт, албаны бэлэн байдал хариуцсан орлогч (ахмад Н.Хадбаатар), “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн Нийгмийн асуудал, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Б.Содхүү) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоодын цэргийн 826 дугаар тусгай салбарын захирагч (хошууч Ж.Гантулга), “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Т.Оюун) нарт даалгасугай.

ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД  
ХУРАНДАА

П.МӨНХБАЯР

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

Б.ХАВГАЛСАЙХАН

Дорнод аймгийн Цагдаагийн газрын дарга,  
“Дорнод бүсийн эрчим хүчний систем”  
ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нарын  
хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 19 -  
ны өдрийн 1106 тушаалын 1 дүгээр  
хавсралт

## **“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСЭД ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ЭД ЗҮЙЛ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг: Нийтлэг үндэслэл**

1.1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хамгаалалтын бүсэд хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйлийг нэвтрүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэ журмын зорилго нь зохих зөвшөөрөлгүй этгээдийг объектод нэвтрүүлэхгүй байх, бараа материал гаргах, оруулах үед шалгаж бүртгэх, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, объектод тогтоосон дэглэм журмыг хэрэгжүүлэхэд оршино.

1.3. Энэхүү журмыг “ДБЭХС” ТӨХК-ийн нийт ажилтан, Дотоодын цэргийн алба хаагчид болон гаднаас нэвтэрч байгаа иргэн бүр мөрдөнө.

### **Хоёр: Объектод нэвтрэх үнэмлэхийн ангилал, түүнийг хэрэглэх:**

2.1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хамгаалалтын бүсэд объектын ажилтан, алба хаагч, тээврийн хэрэгсэл, эд зүйлийг хүчин төгөлдөр баримт бичгийг үндэслэн шалган нэвтрүүлнэ.

2.2. Хүчин төгөлдөр бус баримт бичиг, объектод нэвтрэх эрхийн үнэмлэхгүй хүн, тээврийн хэрэгсэл, эд зүйл оруулах, гаргахыг хориглоно.

2.3. Гадаадын иргэнийг нэг удаагийн зөвшөөрлөөр объектод нэвтрүүлэхдээ гадаад паспорт, Монгол Улсад зорчих визний хүчинтэй хугацаа, холбогдох баримт бичгийг шалгаж, объектын захиргаанаас хариуцах хүнийг байлцуулан нэвтрүүлж, объектод орсон, гарсан тухай бүртгэл хөтөлнө. Бичиг, баримтын зөрчилтэй болон “J” ангилал /жуулчин/-ын визтэй гадаадын иргэнийг объектод нэвтрүүлэхийг хориглоно.

2.4. Энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан гадаадын иргэнийг нэг удаагийн зөвшөөрлөөр объектод нэвтрүүлэхдээ 4 цагийн өмнө мэдэгдэж, визний хуулбарыг Дотоодын цэргийн салбарт ирүүлсэн байна.

2.5. Хугацаагүй хөдөлмөрийн гэрээгээр ажил үүргээ гүйцэтгэж байгаа объектын ажилтан, албан хаагч нь “Байнгын үнэмлэх”-тэй байх бөгөөд объектод нэвтрэх, объектоос гарах бүртээ цаг бүртгэлийн төхөөрөмжид уншуулна.

2.6. “ДБЭХС” ТӨХК-д шинээр ажилд орсон дагалдан ажилтан, гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж буй гаднын компанийн ажилтан, дадлага хийхээр ирсэн оюутан сурагчид болон 24-өөс дээш цагаар ажил гүйцэтгэх гадны иргэд “Түр үнэмлэх”-тэй байх бөгөөд хүчинтэй хугацааг үнэмлэхэд заавал тэмдэглэсэн байна.

2.7. Объектод нэг удаа нэвтрэх иргэнд “Нэг удаагийн нэвтрэх үнэмлэх”-ийг олгоно.



2.8. Энэ журмын 2.5 дахь хэсэгт заасан “Байнгын үнэмлэх”, 2.6 дахь хэсэгт заасан “Түр үнэмлэх”-ийг компанийн Захиргаа, хүний нөөцийн хэлтэс хариуцан ажилд орсон /томилогдсон/ өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор олгоно.

2.9.“Түр үнэмлэх” олгосон бүртгэл судалгааг Захиргаа, хүний нөөцийн хэлтэс хөтлөх бөгөөд өөрчлөлт орсон тохиолдол бүрт хувийг Хамгаалалтын салбарт хүргүүлнэ.

2.10. Энэ журмын 2.7 дахь хэсэгт заасан “Нэг удаагийн нэвтрэх үнэмлэх”-ийг Хамгаалалтын салбарын Хамгаалалтын офицер тухай бүр олгож, бүртгэл хөтлөн хяналт тавина.



**Гурав: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн хамгаалалтын бүсэд хүн, тээврийн хэрэгсэл, бараа материал шалган нэвтрүүлэх ажиллагаа:**

3.1. Объектод хүн, тээврийн хэрэгсэл, бараа материал /мазут, нүүрсээс бусад/-ыг төв хаалга буюу харуулын 1 дүгээр цэгээр, нүүрсийг харуулын хяналтын 2 дугаар цэгээр, мазутыг хяналтын 3 дугаар цэгээр тус тус шалган нэвтрүүлнэ.

3.2. Шаардлагатай тохиолдолд шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь объектод нэвтэрч байгаа албан тушаалтан, ажилтны бие болон гар тээш, тээврийн хэрэгсэлд нарийвчилсан үзлэг, шалгалт хийж болно.

3.3. Байгалийн гамшиг, гэнэтийн осол гарч объектын хэвийн үйл ажиллагаа алдагдсан үед байгууллагын шуурхай албаны болон онцгой байдал, эмнэлгийн яаралтай түргэн тусламж, цагдаагийн байгууллагын тээврийн хэрэгслийг объектод саадгүй нэвтрүүлнэ.

3.4. Объектод нэвтрэх, объектоос гарах байгууллагын хамаарал бүхий тээврийн хэрэгслийн жагсаалтыг Нийтлэг үйлчилгээний хэлтэс, объектоос гарах, объектод нэвтрэх бусад тээврийн хэрэгсэл, бараа материалын зөвшөөрөл /мэдэгдэх хуудас/-ийг Худалдан авах ажиллагааны хэлтэс олгож, Ерөнхий инженер хянана.

3.5. Тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийхдээ эд зүйл, материал оруулах, гаргах зөвшөөрлийн хуудас, жагсаалтыг үндэслэн эзнийг нь байлцуулан ачаа тээшинд байгаа эд зүйлсийн тоо ширхэг, төрөл, нэрсийг жагсаалтын дагуу шалгана.

3.6. Объектод нэвтэрсэн, объектоос гарсан тээврийн хэрэгсэл, бараа материалыг тухай бүр бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

3.7. Объектын ажилтан нь “Байнгын үнэмлэх”-ийг байнгын биедээ авч явах

бөгөөд үнэмлэхээ биедээ авч ирээгүй тохиолдолд тухайн ажилтныг объектын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэнд мэдэгдэж зөвшөөрөл авснаар объектод нэвтрүүлж болно.

3.8. Энэ журмын 3.4 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг үндэслэн объектод тээврийн хэрэгсэл, бараа материалыг ажлын цагаар нэвтрүүлэх, гаргах ба ажлын бус цагаар зайлшгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр нэвтрүүлж, гаргаж болно.

3.9. Баяр, амралтын өдрүүдэд ажиллах ашиглалтын болон засварын ажиллагсдыг Ерөнхий инженерийн баталсан хуваарийн дагуу нэвтрүүлэх ба ажлын зайлшгүй шаардлагаар хяналт тавих, ажил гүйцэтгэхээр ирсэн инженер техникийн ажилтан албан хаагч, удирдах дээд байгууллагаас ирсэн албан тушаалтныг зохих бичиг баримтыг үндэслэн шалган нэвтрүүлнэ.

3.10. Объекттой танилцах, гэрээ хэлцэл хийх, хамтран ажиллах болон бусад ажлаар нэвтрэн орох гадны хүмүүсийг холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийг үндэслэн, зохих бичиг баримтыг шалган нэвтрүүлнэ.

3.11. Захиргаа хүний нөөцийн хэлтсээс нэвтрэх түр үнэмлэх олгосон иргэдэд хамгаалалтын салбарын офицер, алба хаагчид тогтоосон дэглэм журмыг сахиж ажиллах талаар заавар зөвлөмж өгч, баталгаа гаргуулсны дараа нэвтрүүлнэ.

3.12. Объектод 2 болон түүнээс дээш удаа нэвтрэх гадаадын иргэд, төслийн ажилтныг хамгаалалтын бүсэд нэвтрүүлэхдээ объектын захиргаанаас Дотоодын цэргийн штабт ажлын 5 хоногийн өмнө хүсэлт хүргүүлж, зөвшөөрөл авсан байна. Зөвшөөрөл аваагүйн улмаас үүсэх асуудлыг хамгаалалтын салбар хариуцахгүй болно.

3.13. Тэсэрч дэлбэрэх бодис болон шатамхай бараа материалыг нэвтрүүлэхдээ Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн холбогдох албан тушаалтныг байлцуулан шалгаж нэвтрүүлнэ.

3.14. Засвар үйлчилгээ хийхээр гэрээгээр ажиллаж байгаа аж ахуй нэгж, байгууллага нь бараа, материал нэвтрүүлэх тохиолдолд эд зүйлсийн жагсаалтыг 2 хувь үйлдэж, хамгаалалтын салбарын Хамгаалалтын офицерт мэдэгдэж, объектод нэвтрүүлнэ.

3.15. Энэ журмын 3.14 дахь хэсэгт заасан жагсаалтыг үйлдэж объектод нэвтрүүлээгүй тохиолдолд объектоос бараа материалыг гаргахгүй болно.

3.16. Объектод үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэсэгчилсэн хяналт шалгалтын арга хэмжээг согтуурал хэмжигч болон тандагч багаж ашиглан объектын Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэс, Дотоодын цэргийн Хамгаалалтын салбар хамтран зохион байгуулж болно.

3.17. Энэ журмын 3.16 дэх хэсэгт заасан арга хэмжээг зохион байгуулахдаа урьдчилж объектын захиргаагаар удирдамж, төлөвлөгөөг батлуулсан байна.

#### **Дөрөв: Объектын захиргааны хүлээх үүрэг:**

4.1. Компанийн байнгын ажлын байранд хөдөлмөрийн хугацаагүй гэрээгээр ажиллаж буй ажилтнуудад байнгын, компанид шинээр ажилд орсон дагалдан ажилтан, гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж буй гаднын компанийн ажилтан, дадлага хийхээр ирсэн оюутан сурагчдад нэвтрэх түр үнэмлэх олгоно.

4.2. Хамгаалалтын салбарт компанийн нийт ажилтны овог нэр, харъяалагдах нэгж хэсэг, албан тушаалын жагсаалтыг Захиргаа, хүний нөөцийн



хэлтэс улирал тутам шинэчлэн гаргаж өгнө.

4.3. Шалган нэвтрүүлэх үйл ажиллагааны явцад гарсан зөрчлийг баримтжуулахад шаардагдах техник, хэрэгслээр хангана.

4.4. Алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

4.5. Объектод нэвтэрсэн гадны байгууллагын ажилтан, иргэд нь байгууллагын дотоод журмыг чанд биелүүлж, аюулгүй байдлыг чанд сахих үүрэгтэй бөгөөд объектын холбогдох албан тушаалтан үүнд хяналт тавина.

#### **Тав.Хамгаалалтын салбарын хүлээх үүрэг:**

5.1.Хамгаалалтын салбар нь үйлдвэрийн тасралтгүй ажиллагаанд саад учруулахгүйгээр хамгаалалтын аргыг зөв оновчтой сонгож, хамгаалалтыг уян хатан, шуурхай, тасралтгүй зохион байгуулна.

5.2.Объектод нэвтрэн орж байгаа ажилтан, алба хаагчдын ажлын үнэмлэхийг шалган нэвтрүүлэх ба объектод танилцах, гэрээ хэлцэл хийх, хамтран ажиллах болон бусад ажлаар нэвтрэн орох гадны хүмүүсийг холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийг авч, иргэний цахим үнэмлэхийг шалгаж объектод нэвтрүүлнэ.

5.3.Объектод нэвтэрч байгаа эд зүйл, бараа материал, овор ихтэй ачаа, тээш, тээврийн хэрэгсэлд шаардлагатай бол Дотоодын цэргийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дахь хэсэгт заасны дагуу үзлэг, шалгалтыг явуулж болно.

5.4.Зөвшөөрөлгүй эд зүйлс авч явсан этгээдийг Дотоодын цэргийн тухай хуулийн 33.1.2 дахь хэсэгт заасны дагуу саатуулж, цагдаагийн байгууллагад шилжүүлэн, энэ тухай объектын захиргаанд мэдэгдэнэ.

5.5.Архи, согтууруулах ундааг амьсгал дахь спиртийн агууламж 0,20 промилль (‰) буюу 0,02%-ийн зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлсэн, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл болон мансууруулах бодис хэрэглэсэн ажилтан, алба хаагч, иргэнийг объектод нэвтрүүлэхгүй бөгөөд алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн тохиолдолд хуульд заасан шат дараатай арга хэмжээ авна.

5.6.Объектод орох, гарах хүн, бараа материал, тээврийн хэрэгслийг шалгах явцад илэрсэн зөрчлийг объектын захиргаанд сар бүрийн 20-ны өдрийн дотор бичгээр хүргүүлнэ.

5.7.Гэрээгээр ажиллаж буй гадны байгууллага нь энэ журмыг удаа дараа зөрчсөн бол объектод нэвтрүүлэхгүй байж болно.

5.8.Үйлдвэрлэлийн объектод хяналт шалгалт зохион байгуулахдаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, компанийн дотоод журмыг мөрдөж, аюулгүй байдлыг бүрэн хангаж, хамгаалах хэрэгсэл, каск өмсөж үүрэг гүйцэтгэнэ.

5.9.Компанийн инженер техникийн ажилтан, ажилтнуудын нэгэн адил хувийн машин, техник хэрэгслийг хашааны гадна байрлуулна.

5.10.Шалган нэвтрүүлэх, хяналтын цэгүүдийн ойр орчмын 2 метр хүртэлх талбайн цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэнэ.

#### **Зургаа:Шалган нэвтрүүлэх ажиллагааны үед хориглох зүйл:**

6.1. Баяр ёслол, амралтын өдрүүдэд холбогдох албан тушаалтны зөвшөөрөлгүй хүн (хуваарийн дагуу ажиллах ээлжийн ажилтан, үзлэг шалгалт хийхээр ирсэн инженер техникийн ажилтан хамаарахгүй) ба тээврийн хэрэгсэл бараа материал нэвтрүүлэхийг;

6.2. Объектод 16 наснаас доош насны хүүхэд /тусгай арга хэмжээнд уригдсан, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр танилцахаар ирсэнээс бусад тохиолдолд/ нэвтрүүлэхийг;

6.3. Нэг удаагийн үнэмлэхээр нэвтэрсэн иргэн зөвхөн уулзах хүнтэйгээ уулзаад гарах ба объектын бусад хэсгээр явахыг;

6.4. Объектод нэвтрэх эрх бүхий тээврийн хэрэгслийн жагсаалтад ороогүй болон зохих зөвшөөрлийн бичиггүй тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхийг;

6.5. Объектод дараах эд зүйлийг нэвтрүүлэхийг хориглоно

6.5.1 Архи, согтууруулах ундаа;

6.5.2 Тэсэрч дэлбэрэх, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, хордуулах, мансууруулах болон цацраг идэвхт бодис, зэвсэг хэрэгсэл;

6.5.3 Тэжээвэр амьтан;

6.6 Журамд зааснаас өөр хаалгаар нэвтрэх, үнэмлэхэд заасан хугацааг хэтрүүлэх, бусдын үнэмлэхийг ашиглах;

6.7 Хамгаалалтын бүсэд согтуугаар нэвтрэх, объектод согтууруулах ундаа хэрэглэх;

### **Долоо: Албан бичгээр харилцах журам**

7.1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн хамгаалалтын бүсэд зайлшгүй ажлын шаардлагаар ажил гүйцэтгэх гаднын байгууллагын иргэд, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхдээ тухайн байгууллагын албан бичгийг үндэслэж нэвтрэх зөвшөөрөл олгоно.

7.2. Зөвшөөрөл олгосон албан бичигт дараах зүйлсийг тусгасан байна.

7.2.1. Ажлын зорилго, ажиллах хүн хүч, овог нэр, регистрийн дугаар, тээврийн хэрэгслийн улсын дугаар, техник, цаг хугацаа тодорхой байх;


7.2.2. Ажиллах объект, хариуцан ажиллах албан тушаалтныг томилох;

7.3. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулахдаа аль нэг талдаа албан бичгээр хандаж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗАР

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ" ТӨХК

Дорнод аймгийн Цагдаагийн газрын дарга, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нарын хамтарсан 2024 оны 10 дүгээр сарын 19-ны өдрийн 1/106 тушаалын 2 дугаар хавсралт



### "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСЭД НЭВТРЭХ ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

#### Нэг. "Байнгын үнэмлэх"-ний загвар:

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦЛАТ КОМПАНИ

**Б.СОДХҮҮ**

Захиргаа, хүний нөөцийн хэлтэс  
Нийгмийн асуудал,  
дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦЛАТ КОМПАНИ

Гүйцэтгэх захирал  
*Б.Содхуу* **Б.Жаргалсайхан**

#### Хоёр. "Түр үнэмлэх"-ний загвар:

**ТҮР ҮНЭМЛЭХ**

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК

..... оны ..... дугаар сарын ..... ны өдрөөс

ОВОГ НЭР: .....

..... оны ..... дугаар сарын ..... хүртэл түр үнэмлэх олгов.

АЛБАН ТУШААЛ: .....

Сунгалт: ..... оны ..... дугаар сарын ..... өдөр

ҮЙЛДВЭРТ НЭВТРЭХ ЗОРИЛГО:  
.....  
.....

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
Т.ОЮУН

Олгосон ..... он ..... сар ..... өдөр



Гурав. "Нэг удаагийн нэвтрэх үнэмлэх"-ний загвар:

**НЭГ УДААГИЙН НЭВТРЭХ ҮНЭМЛЭХ №**

\_\_\_\_\_ иргэний үнэмлэхтэй \_\_\_\_\_ ажилтай  
\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь 2023 оны \_\_\_\_\_ сарын  
\_\_\_\_\_ ны өдрийн \_\_\_\_\_ цагт \_\_\_\_\_ объектын \_\_\_\_\_ ажилтай  
\_\_\_\_\_ тэй уулзахаар орж \_\_\_\_\_ цагт гарав


Нэвтрэх үнэмлэх олгосон: \_\_\_\_\_ албан тушаалтай \_\_\_\_\_ /нэр/  
Уулзсан хүн: \_\_\_\_\_ /нэр, гарын үсэг/

ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗАР

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ" ТӨХК



Дорнод аймгийн Цагдаагийн газрын дарга,  
"Дорнод бүсийн эрчим хүчний систем"  
ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нарын  
хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 29 -  
ны өдрийн А/106 тушаалын 3 дугаар  
хавсралт



**ОБЪЕКТОД НЭВТРҮҮЛЭХ БАРАА  
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ  
/ЗАГВАР/**

Д/д	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Буцаж объектод орох эсэх /Буцаж объектоос гарах эсэх/
1			
2			
3			
4			
5			

Жич: Жагсаалтыг 2 хувь үйлдэж, объектын ажилтан 1 хувийг, хамгаалалтын ажилтан 1 хувийг тус тус хадгална.

ХЯНАСАН:  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР..... /...../

БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ ГАРГАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА ..... /...../

Тэмдэг дарж баталгаажуулна

ШАЛГАСАН:  
ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАН .....

Дардас дарж баталгаажуулна

ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗАР

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ" ТӨХК

Дорнод аймгийн Цагдаагийн газрын дарга,  
"Дорнод бүсийн эрчим хүчний систем"  
ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нарын  
хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 29 -  
ны өдрийн А/1006 тушаалын А дүгээр  
хавсралт

ЖСЭЯДСЗ 4-9020413

### ОБЪЕКТООС ГАРГАХ БАРАА, МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ /ЗАГВАР/

Зөвшөөрөл авагчийн овог ..... нэр .....

Зорилгоор дараах зүйлийг гаргахыг зөвшөөрөв.

№	Бараа материалын үнэт зүйл	Код	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1				
2				
3				
4				
5				

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР..... /...../

БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ ГАРГАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА ..... /...../

Тэмдэг дарж баталгаажуулна

ШАЛГАСАН:

ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАН .....


Дардас дарж баталгаажуулна

ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗАР

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ" ТӨХК



Дорнод аймгийн Цагдаагийн газрын дарга,  
"Дорнод бүсийн эрчим хүчний систем"  
ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нарын  
хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 19 -  
ны өдрийн А/106 тушаалын 5 дугаар  
хавсралт



ОБЪЕКТОД ИРГЭНИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАХ, НЭВТРҮҮЛЭХ  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

Д/д	Албан тушаал
1	Гүйцэтгэх захирал
2	Ерөнхий инженер
3	

ДОРНОД АЙМГИЙН ЦАГДААГИЙН  
ГАЗАР

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ" ТӨХК